



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Монгол хүүхдийн хоол тэжээлийн
бодисуудын зөвлөмж хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолд заасныг үндэслэн Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээ, дэглэмийг нэгдүгээр, 1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг хоёрдугаар, хүнсний бүтээгдэхүүнийг хоолонд зориулан боловсруулахад гарах хорогдлын хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг), Эрүүл мэндийн яамны дэргэдэх хоол судлал, хүнсний аюулгүй мэргэжлийн салбар зөвлөл (Б.Бямбатогтох)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

221
Эрүүл мэндийн сайдын
2014 оны 04 сарын 08 өдрийн
113 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХЭРЭГЦЭЭТ
ИЛЧЛЭГ, ХОНОГИЙН ХООЛНЫ ХЭМ ХЭМЖЭЭ, ДЭГЛЭМ

1. Хүүхдийн хоол нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 247 тоот тушаалаар батлагдсан "Хүн амын зөв хооллолтын зөвлөмж"-ийн шаардлагад нийцсэн байна.
2. Хүүхдийн байгууллагуудад хүүхдийн хоолыг хүйсийн ялгавартайгаар бэлдэн, үйлчлэх боломжгүйг харгалзан 1-3 настай хүүхдэд 1200 ккал, 4-6 настай хүүхдэд 1600 ккал, 7-10 настай хүүхдэд 2000 ккал, 11-14 настай хүүхдэд 2100 ккал, 15-18 настай хүүхдэд 2300 ккал илчлэгтэй хоол хүнс хэрэглэхээр тооцно.
3. Хүүхдэд шаардлагатай нийт илчлэгийг дараах байдлаар хуваарилан ноогдуулна. Үүнд:
 - Өглөөний хоол 20%
 - Бага үдийн цай 10-15%
 - Үдийн хоол 30-35%
 - Их үдийн цай 10%
 - Оройн хоол, цай 20-25%
4. Байгууллагын болон үзүүлж буй үйлчилгээний төрөл, хүүхдийн цэцэрлэг, сургуульд байх цаг хугацаанаас хамаарч тухайн насны хүүхдэд шаардлагатай хоногийн хэрэгцээт илчлэгийн тодорхой хувийг хангахуйц хэмжээний хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх шаардлагатай. Тухайлбал, тухайн насны бүлгийн хүүхдэд шаардлагатай хоногийн хэрэгцээт илчлэгээс:
 - 8 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт - 75-80 хувь,
 - 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт - 100 хувь,
 - сургуулийн дотуур байранд - 100 хувь,
 - үдийн цай хөтөлбөрөөр - 10-15 хувь,
 - сургуулийн үдийн хоолоор - 30-35 хувийг авахаар тус тус тооцож, хоолны цэсийг төлөвлөж, хүнсний бүтээгдэхүүнээр хангах шаардлагатай.
5. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг тооцож, төлөвлөнө. Өөрөөр хэлбэл худалдан авалт хийдээ тухайн бүтээгдэхүүний жишиг хэмжээн дээр бүтээгдэхүүний цэвэрлэгээ, боловсруулалтын үед гарах хорогдлын хэмжээг нэмж тооцно гэсэн үг юм.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
04 сарын 08 өдрийн 18 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

1-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ


Нэг. 1-3 нас

	Бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл)	Илчлэг (ккал)	Уураг (гр)		Тос (гр)		Нүүр ус (гр)
				Амьтан	Ургамал	Амьтан	Ургамал	
Мах, махан бүтээгдэхүүний бүлэг								
1	Мах	100	132.2	19.7	0	5.3	0	0
2	Өндөг	10	15.71	1.27	0	1.15	0	0.07
Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг								
1	Сүү	120	76.6	3.9	0	4.2	0	5.76
2	Тараг, аарц, ээдэм	150	140.2	4.3	0	4.6	0	20.2
Үр тарианы бүлэг								
1	Гурил	50	162.5	0	4.7	0	0.5	34.9
2	Гурилан бүтээгдэхүүн	100	279.9	0	10.9	0	2.7	53
3	Төрөл бүрийн будаа	25	85.7	0	1.85	0	0.55	18.3
4	Төмс	50	43.8	0	1	0	0.05	9.85
Хүнсний ногооны бүлэг								
1	Хүнсний ногоо	100	22.4	0	1	0	0	4.6
2	Буурцагт ургамал	10	29.8	0	2.05	0	0.2	0.46
Жимс, жимсгэний бүлэг								
1	Жимс, жимсгэнэ	100	46.8	0	0.4	0	0	11.3
Тосны бүлэг								
1	Ургамлын тос	15	134.73	0	0	0	14.97	0
Бусад								
1	Чихэр, чихэрлэгийн зүйл	10	39.92	0	0	0	0	9.98
2	Давс	2						
				29.28	21.85	15.3	18.97	168.47
Дүн				51.1		34.2		168.47

1-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ

Хоёр. 4-6 нас


	Бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл)	Илчлэг (ккал)	Уураг (гр)		Тос (гр)		Нүүр ус (гр)
				Амьтан	Ургамал	Амьтан	Ургамал	
Мах, махан бүтээгдэхүүний бүлэг								
1	Мах	130	171.9	25.6	0	6.9	0	0
2	Өндөг	15	23.6	1.9	0	1.7	0	0.1
Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг								
1	Сүү	120	76.7	4.0	0	4.2	0	5.8
2	Тараг, аарц, ээдэм	150	140.3	4.4	0	4.7	0	20.3
Үр тарианы бүлэг								
1	Гурил	80	260.0	0	7.4	0	0.8	55.8
2	Гурилан бүтээгдэхүүн	150	419.9	0	16.4	0	4.1	79.5
3	Төрөл бүрийн будаа	40	137.2	0	3.0	0	0.9	29.4
4	Төмс	100	87.7	0	2.0	0	0.1	19.7
Хүнсний ногооны бүлэг								
1	Хүнсний ногоо	130	29.1	0	1.3	0	0	6.0
2	Буурцагт ургамал	15	44.7	0	3.1	0	0.3	0.7
Жимс, жимсгэний бүлэг								
1	Жимс, жимсгэнэ	120	56.2	0	0.5	0	0	13.6
Тосны бүлэг								
1	Ургамлын тос	20	179.6	0	0	0	20.0	0
Бусад								
1	Чихэр, чихэрлэгийн зүйл	15	59.9	0	0	0	0	15.0
2	Давс	2		35.8	33.6	17.5	26.1	245.6
Дүн				69.4		43.6		245.6




1-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ

Гурав. 7-10 нас

	Бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл)	Илчлэг (ккал)	Уураг (гр)		Тос (гр)		Нүүр ус (гр)
				Амьтан	Ургамал	Амьтан	Ургамал	
Мах, махан бүтээгдэхүүний бүлэг								
1	Мах	150	198.3	29.6	0	8.0	0	0
2	Өндөг	20	31.4	2.5	0	2.3	0	0.1
Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг								
1	Сүү	140	89.5	4.6	0	4.9	0	6.7
2	Тараг, аарц, эздэм	180	168.3	5.2	0	5.6	0	24.3
Үр тарианы бүлэг								
1	Гурил	90	292.5	0	8.4	0	0.9	62.7
2	Гурилан бүтээгдэхүүн	180	503.8	0	19.6	0	4.9	95.4
3	Төрөл бүрийн будаа	50	171.5	0	3.7	0	1.1	36.7
4	Төмс	120	105.2	0	2.4	0	0.1	23.6
Хүнсний ногооны бүлэг								
1	Хүнсний ногоо	150	33.6	0	1.5	0	0.0	6.9
2	Буурцагт ургамал	20	59.6	0	4.1	0	0.4	0.9
Жимс, жимсгэний бүлэг								
1	Жимс, жимсгэнэ	140	65.5	0	0.6	0	0	15.8
Тосны бүлэг								
1	Ургамлын тос	20	179.6	0	0	0	20.0	0
Бусад								
1	Чихэр, чихэрлэгийн зүйл	20	79.8	0	0	0	0	20.0
2	Давс	2		41.9	40.3	20.7	27.3	293.2
Дүн				82.2		48.1		293.2





1-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ

Дөрөв. 10-14 нас

	Бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл)	Илчлэг (ккал)	Уураг (гр)		Тос (гр)		Нүүр ус (гр)
				Амьтан	Ургамал	Амьтан	Ургамал	
Мах, махан бүтээгдэхүүний бүлэг								
1	Мах	170	224.7	33.5	0.0	9.0	0.0	0.0
2	Өндөг	20	31.4	2.5	0.0	2.3	0.0	0.1
Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг								
1	Сүү	160	102.2	5.3	0.0	5.6	0.0	7.7
2	Тараг, аарц, ээдэм	200	187.0	5.8	0.0	6.2	0.0	27.0
Үр тарианы бүлэг								
1	Гурил	100	325.0	0.0	9.3	0.0	1.0	69.7
2	Гурилан бүтээгдэхүүн	190	531.8	0.0	20.7	0.0	5.1	100.7
3	Төрөл бүрийн будаа	50	171.5	0.0	3.7	0.0	1.1	36.7
4	Төмс	130	114.0	0.0	2.6	0.0	0.1	25.6
Хүнсний ногооны бүлэг								
1	Хүнсний ногоо	170	38.1	0.0	1.7	0.0	0.0	7.8
2	Буурцагт ургамал	20	59.6	0.0	4.1	0.0	0.4	0.9
Жимс, жимсгэний бүлэг								
1	Жимс, жимсгэнэ	160	74.9	0.0	0.6	0.0	0.0	18.1
Тосны бүлэг								
1	Ургамлын тос	25	224.6	0.0	0.0	0.0	25.0	0.0
Бусад								
1	Чихэр, чихэрлэгийн зүйл	20	79.8	0.0	0.0	0.0	0.0	20.0
2	Давс	<5		47.1	42.8	23.1	32.7	314.3
Дүн				89.9		55.8		

1-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ

Тав. 15-18 нас

	Бүтээгдэхүүний нэр	Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл)	Илчлэг (ккал)	Уураг (гр)		Тос (гр)		Нүүр ус (гр)
				Амьтан	Ургамал	Амьтан	Ургамал	
Мах, махан бүтээгдэхүүний бүлэг								
1	Мах	185	244.6	36.4	0	9.8	0	0
2	Өндөг	20	31.4	2.5	0	2.3	0	0.1
Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг								
1	Сүү	170	108.6	5.6	0	6.0	0	8.2
2	Тараг, аарц, ээдэм	200	187.0	5.8	0	6.2	0	27.0
Үр тарианы бүлэг								
1	Гурил	110	357.5	0	10.2	0	1.1	76.7
2	Гурилан бүтээгдэхүүн	210	587.8	0	22.9	0	5.7	111.3
3	Төрөл бүрийн будаа	60	205.8	0	4.4	0	1.3	44.0
4	Төмс	140	122.8	0	2.8	0	0.1	27.6
Хүнсний ногооны бүлэг								
1	Хүнсний ногоо	180	40.3	0	1.8	0	0.0	8.3
2	Буурцагт ургамал	20	59.6	0	4.1	0	0.4	0.9
Жимс, жимсгэний бүлэг								
1	Жимс, жимсгэнэ	170	79.6	0	0.7	0	0	19.2
Тосны бүлэг								
1	Ургамлын тос	25	224.6	0	0	0	25.0	0
Бусад								
1	Чихэр, чихэрлэгийн зүйл	20	79.8	0	0	0	0	20.0
2	Давс	<5		50.4	46.9	24.3	33.6	343.3
Дүн				2329.4	97.3		57.8	

Тайлбар: -Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн 1 дүгээр зэргийн өөхгүй мах, сүүг 3 хувийн тослогтой үнээний сүү, тараг 3.5 хувийн тослогтой, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг булочикоор, будааг цагаан будаагаар, хүнсний ногоог байцаагаар, жимсийг алимаар, буурцагт ургамлыг вандуйгаар, ургамлын тосыг наранцэгийн тосоор төлөөлүүлэн авсан болно.
-Энэ зохицуулалт нь хоол хүнсээр авах илчлэг, шимт бодисуудын зохистой харьцааг хадгалахад чиглэгдэнэ.

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 04 сарын 08 өдрийн
113 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХООЛОНД ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛАХАД
ГАРАХ ХОРОГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Хүнсний бүтээгдэхүүнийг цэвэрлэх үеийн хорогдол /Бохир жингээс бодох хувь/	Хүнсний бүтээгдэхүүнд халуун боловсруулалт хийх үеийн хорогдол /Цэвэр жингээс бодох хувь/
1	Төрөл бүрийн малын мах	Бог (25-30%) Бод (26% хүртэл)	
	Дайвар бүтээгдэхүүн	Хэл – хорогдол байхгүй Бөөр, зүрх, элэг (2-15%)	
2	Загас	Шинэ хөлдүү загас 30-48%	Чанасан -20% Жигнэх -18%
3	Төрөл бүрийн малын сүү	Хорогдол байхгүй	Дулааны боловсруулалт хийх үед жингийн хорогдол гарч болно.
4	Төмс	VIII – IX/1 хүртэл - 20% IX - XI сар - 25% XI - I сар - 30% I - IV сар - 35% IV - VIII сар - 40%	Хальслаад чанах -3%
5	Лууван	20-25%	Хальслаад: Бүхлээр нь чанах - 0.5% Хэрчиж чанах, жигнэх - 8% Хэрчиж хуурах - 32%
6	Шинэ бөөрөнхий байцаа	20%	Хэрчиж жигнэх - 21% Хэрчиж чанах - 10%
7	Шар манжин	25%	Хэрчиж чанах - 8% Хэрчиж жигнэх - 23% Хэрчиж хуурах - 23%
8	Хүрэн манжин	25%	Хальслаад: Бүхлээр нь чанах - 5% Хэрчиж чанах, жигнэх - 8%
9	Хулуу	Урт хулуу (zucchini) -2% Шар хулуу (pumpkin) -25-30%	Хэрчиж чанах, жигнэх - 17%
10	Улаан лооль	2%	
11	Шинэ өргөст хэмх	2%	
12	Сонгино	16%	
13	Саримс	20%	